

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛТ

Нэр төрлийн дугаар	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Техникийн тодорхойлолт болон, стандартат тавигдах шаардлага
Багц 1 <i>Мах махан бүтээгдэхүүн</i>	Үхэр, хонины мах	<ol style="list-style-type: none">1. Үхэр, хонины 1-р зэргийн, өнгө, үнэр, биет байдал, гадаргуу хэлбэр алдагдаагүй мах байна.2. Махыг хэсэглэж ангилсан байдлаар нийлүүлэх тохиолдолд MNS 2456:2009, MNS 2457:2009 стандартуудын шаардлагыг хангасан байна.3. Эрүүл ахуй, аюулгүй байдлын үндсэн шаардлага хангасан, эрүүл малаас бэлтгэсэн байна.4. Мал эмнэлэг, гарал үүслийн гэрчилгээ, хүнсний лабораторийн шинжилгээний бичигтэй байна.5. Загсаасан буюу сэрвээсэн эсвэл хөргөсөн, хөлдөөсөн мах байна.6. Нөжөрч хурсан цус, зэвс, үс, шороо зэрэг гадны бохирдолгүй, гадаргуй нь урагдаж гэмтээгүй байна.7. Эрүүл ахуйн шаардлага хангасан тээврийн хэрэгсэлээр тээвэрлэнэ.8. Дулааны улиралд зориулалтын хөргүүрт хадгалах.9. Тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцад технологийн горимыг чанд мөрдөнө.10. Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар 1 удаагийн нийлүүлэлтийг хийнэ.

<p align="center">Багц 2</p> <p align="center">Гурил, гурилан бүтээгдэхүүн</p>	<p align="center">Гурил</p>	<ol style="list-style-type: none"> 1. Үр тарианы гурил нь их орны болон орон нутгийн үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. 2. Нийлүүлэх гурил нь дээд буюу БГ-055, 1-р зэрэг буюу БГ-085 стандартын шаардлага хангасан байх 3. Гурил нь 15.5%-иас ихгүй чийглэгтэй, 22-с багагүй цавуулагтай 4. Гадны үнэр, амтгүй, хортон шавьж, өндөг, авгалдай илрэх ёсгүй 5. Гурилын шуудай MNS 2515:1994 стандартын шаардлага хангасан шуудай уутанд савласан байна 6. Хаяг, шошгын стандартын шаардлага хангасан байна 7. Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан тээврийн хэрэглэсээр тээвэрлэнэ 8. Тээвэрлэлт, хадгалалт, борлуултын явцад технологийн горимыг чанд мөрдөнө 9. Бүтээгдэхүүнийг ажлын 14 хоногийн хэрэгцээг хангахуйцаар 1 удаагийн нийлүүлэлтийг хийнэ <p>/ MNS 0244:2009 нийцсэн физик химийн үзүүлэлтээр чийг 12.4%, үнслэг 0.81%, хүчиллэг 3град ширхэг үлдэгдэл 3.2% нойтон цавуулаг 27.4% төмөрлөг хольц 00, мэдрэхүйн үзүүлэлтээр буудай гурилын хэвийн амт үнэртэй исгэсэн буюу хөгцний зэрэг гадны үнэргүй нэр төрөлдөө тохирсон өнгөтэй зажлахад хатуу буюу элсэрхэг зүйл зажлагдахгүй</p>
	<p align="center">Талх, хөөмөл боов</p>	<p>Улсын ба салбарын стандарт, техникийн нөхцөл бусад норматив, техникийн баримт бичигт заасан хүүхдийн хүнсэнд хэрэглэж болох чанарын баталгаатай материал, нарийн боовны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг хэрэглэнэ. Нарийн боовыг хуурай цэвэр гадны элдэв үнэргүй, өөр өөрийн хэлбэр дүрстэй, дутуу зуурагдсан шинж тэмдэггүй, нэр төрөлдөө тохирсон амт үнэртэй, жигд сийрэгжилттэй, гадны хольцгүй, гүйцэт бололттой, шинжилгээгээр чийглэг, хүчиллэг, сийрэгжилт нь зөвшөөрөгдөх хэмжээндээ байх ба нянгын бохирдолүй байх. Нарийн боовийг хурц үнэртэй өөр төрлийн бараатай хамт тээвэрлэхийг хориглоно. Түргэн гэмтдэг барааг тусгай зориулалтын чанарыг алдуулахгүйгээр тээвэрлэнэ.Зөвхөн батлагдсан стандарт техникийн нөхцөл чанарын баталгаатай барааг хүлээн авна. Хүлээн авахдаа хайрцаг савны байдал хаяг шалгана.</p>

		Хайрцаг саван дээр үйлдвэрлэсэн огноо, 2 хадгалах горим, цэвэр бохир жин зэргийг заасан шошготой байна. Чанаргүй буюу гологдол бүтээгдэхүүн хүлээн авахыг хориглоно.
Багц 3 Сүү сүүн бүтээгдэхүүн	Сүү	<p>Сүү, аарц, тараг, эззгий, ааруул, цөцгий багтдаг. Гадны бохирдолгүй сүү сүүн бүтээгдэхүүний ариун цэврийн шаардлага хангасан гэрчилгээтэй, амт үнэр сайтай, гашлаагүй, сав баглаа боодол гэмтэлгүй битүү саванд хурааж тээвэрлэсэн, чийглэг нь тохирсон, гашлах болон гашуун элдэв төрлийн амт үнэргүй байх</p> <ol style="list-style-type: none"> 1. Малын вакцин, тарилга, туулгад хамрагдсан тухайд бүтээгдэхүүнийг нийлүүлэхгүй байх ба урьдчилан мэдэгдэнэ 2. Бүтээгдэхүүнийг хэрэглэх заавар, зөвлөмж зэрэг нэмэлт мэдээллийг дагалдуулж болно 3. Нийлүүлэгдэх тараг нь эсэглэн цагаан идээ техникийн шаардлага MNS 4230:2003 бяслаг, аарц, ааруул нь уураглаг цагаан идээ техникийн шаардлага MNS 4230:2003 стандартууд болон эрүүл ахуйн аюулгүй байдлын шаардлага хангасан байна 4. Үйлдвэрийн болон уламжлалт аргаар бэлтгэсэн, нэгэн жигд бие бүтэцтэй, тослог зохих түвшинд байна 5. Цагаан өнгөтэй, шинэлэг байдлаа хадгаласан, нэгэн жигдгүй бүтэцтэй тослог зохих түвшинд байна <p>Бүтээгдэхүүнийг ажлын 2-14 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.</p>
	Аарц, ааруул, эззгий	Монгол аргаар бэлтгэгдсэн, төрөл бүрийн хэлбэртэй байна. Хэт хатаасан биш, хөгцрөөгүй, ааруул цагаан өнгөтэй чихэрлэг амттай, эззгий шаргал өнгөтэй байна
	Тараг	Монгол аргаар бэлтгэгдсэн исээгүй нэгэн жигд бүтэцтэй, хэт шингэн биш байх. Задгай тараг нь эрүүл ахуйн шаардлага хангасан таглаатай битүү битонд савлагсан байна.
	Цөцгий	Цөцгий -MNS 2842:1981, MNS 4505:2008- цайвар шаргал өнгөтэй, нэр төрөлдөө тохирсон үнэр, амттай, гадны механик хольцгүй, нян, хөгц, мөөгөнцөр илрээгүй байна. Уураглаг цагаан идээ. MNS 4230:2005 Техникий

	Масло	Масло /цөцгийн тос/техникийн шаардлага MNS 6652:2017 Сүү ХХК маслотой дүйцэхүйц, тослог 82%. исгэлэн 2к ,БЕТоо 1мл-т 1*10, ГБТЭН 25мл-т илрэх илрээгүй болн
Багц 4 Бусад хуурай хүнс	Исгэгч	MNS ISO 4293:1995 стандартад нийцсэн, шаргалдуу туяатай, саарал өнгөтэй, хөгц янз бүрийн үнэргүй, наалдаагүй байна
	Молоко	Молоко: бүтээгдэхүүн нь үйлдвэрлэгдсэн болон хадгалалтын хугацаа тодорхой заагдсан, монгол заавартай, лаазны таглаа татуурган онгойлгогчтой, хайрцаг сав нь бүрэн бүтэн, хонхойж хэмхрээгүй байна. Шингэн бүтээгдэхүүн нь тунадас үүсээгүй, тухайн бүтээгдэхүүний тохирсон үнэртэй. Гарал үүслийн гэрчилгээ, шинжилгээний дүгнэлттэй байна.
	Ургамлын тос	Ургамлын тос нь: MNS CAC 125:1998 стандартад нийцсэн гадны үнэргүй, нэр төрөлдөө тохирсон өнгөтэй, нягт, г/см куб 0.92, хугарлын илтгэгч нь 190.4 болно. Транс тосны агууламжгүй байх
	Элсэн чихэр	Элсэн чихэр нь: MNS 4:95 стандартад дүйцэхүйц стардарт эрүүл ахуйн шаардлага хангасан. Хүнсний аюулгүй байдлыг үндсэлий лавлагаа лабораторийн эрүүл ахуйн нян судлалын хяналтын лаборатори эрүүл ахуйн хор судлалын хяналтын лаборатори ургамлын эрүүл ахуй хорио цээрийн итгэмжлэгдсэн лаборатори УЭА 1773 тоот цацрагын хяналтын итгэмжлэгдсэн лабораторийн х/0221 тоот шинжилгээ. Ургамлын эрүүл ахуйн хорио цээрийн шинжилгээгээр элсэн чихэр нь цэвэршүүлсэн ба тастжуулсан сахарын хольцгүй чийглэг 0.02% үнслэг 0.07% сахароз 99.74 хорио цээртэй хөнөөлт шавьж хатиг, тэдгээрийн өндөг авгалдай илрээгүй, эрүүл ахуйн нян судлалын шинжилгээгээр колиформ SALIMONEL 1гр-д хөгц мөөгөнцөр тус тус илрээгүй хүнд мералын үлдэгдэл тодорхойлогдох шинжилгээгээр кадми 0.001 мл/кг хар тугалаг 0.054 зөвшөөрөгдөх хэмжээ байна.
	Далайн байцаа	Солонгос улсад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц, Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн
	Давс	MNS CAC 150:2007. Үндэсний үйлдвэрлэлийн, нуурын, жамц давс байна. Иоджуулсан давс авахгүй. /Нунтаг цагаан өнгөтэй, бөөгнөрч чийг аваагүй, хатуураагүй байна./ Эх

		оронд үйлдвэрлэгдсэн, сайн чанарын иоджуулсан давстай дүйцэхүйц сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн.
	Цайны идээ	Дугуй булант, болон хадагтай цайны төрөл сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн
	Хар чавга	Хар чавга: MNS CAC 67:1999 хэлбэр дүрсээ алдаж гэмтээгүй, гүйцэт боловсорсон, зөөлөн эд нь нягт хатуу байдалтай, зөв хэлбэр дүрстэй, хортон шавьж мэрэгч, хачиг, авгалдай илрээгүй, хөгцөрч муудаагүй, ялзраагүй, гадны амт үнэргүй, хөлдөөгүй, хатаж чийгээ алдаагүй, ургамлын хорио цээрийн шаардлага хангасан, гарал үүслийн гэрчилгээ, шинжилгээний дүгнэлттэй байна
	Үзэм	Үзэм: MNS CAC 67:1999 Хүрэн бор, шаргал өнгөтэй чихэрлэг гадны гаж амтгүй шороо чулуугүй, эрүүл ахуйн чанар хангасан, сайн чанарын эрүүл ахуйн, ариун цэврийн стандарт шаардлагад нийцсэн
	Алим	Алим: MNS CAC 299:2014 - нь хэлбэр дүрсээ алдаж гэмтээгүй, гүйцэт боловсорсон, зөөлөн эд нь нягт хатуу байдалтай, зөв хэлбэр дүрстэй, хортон шавьж мэрэгч, хачиг, авгалдай илрээгүй, хөгцөрч муудаагүй, ялзраагүй, гадны амт үнэргүй, хөлдөөгүй, хатаж чийгээ алдаагүй, ургамлын хорио цээрийн шаардлага хангасан, гарал үүслийн гэрчилгээ, шинжилгээний дүгнэлттэй байна.
	Банана	Банана: MNS 67: 080 - нь хэлбэр дүрсээ алдаж гэмтээгүй, гүйцэт боловсорсон, зөөлөн эд нь нягт хатуу байдалтай, зөв хэлбэр дүрстэй, хортон шавьж мэрэгч, хачиг, авгалдай илрээгүй, хөгцөрч муудаагүй, ялзраагүй, гадны амт үнэргүй, хөлдөөгүй, хатаж чийгээ алдаагүй, ургамлын хорио цээрийн шаардлага хангасан, гарал үүслийн гэрчилгээ, шинжилгээний дүгнэлттэй байна.
	Нарийн гоймон, мушгиа гоймон	Алтан тариан лапша гоймонтой дүйцэхүйц сайн чанарын, эрүүл ахуйн, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн / MNS 142-85 хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ундны ус хүнсний хими хор судлал хөгц мөөгөнцөр хүнд металын лабораторийн 15340-15346 тоот шинжилгээний дүнгийн тэмдэглэлтэй. Нэр төрөлдөө тохирсон амт, цагаан сааралл өнгөтэй, гадаргуу хугарч үйрээгүй, хөгц

		мөөгөнцөр илрээгүй, гашуун исгэлэн буюу гадны амт үнэргүй, төмрийн хольцгүй, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч болон төмсний савханцар илрээгүй чийглэг, хүчиллэг, төмөрлөгийн үзүүлэлт нь чанарын шаардлага ханагасан зөвшөөрөгдөх хэмжээнд байна
	Хөндий гоймон, шпагети	MNS 0142:1985. Гадны хольцгүй, хэрчилт жигд, хэлбэр дүрсээ алдаагүй, гүйцэд чанахад хэлбэр дүрсээ алдахгүй, усанд уусч хоорондоо наалдахгүй, хүчиллэг, чийг, хүнд металлын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд, эмгэг төрөгч, нян илрээгүй байна.
	Цагаан будаа	Цагаан будаа нь MNS ISO 7301-2000 ГОСТ 0292-93 Харлаж цоохортоогүй, хөгцний амт үнэргүй, хортон мэрэгч шавьж, тэдгээрийн өт, авгалдай, ялгадасаар бохирлогдоогүй байна. Том ширхэгтэй, цагаан будааны тоос, буталсан үрийн хэсэггүй байна. Өнгө нь хэт цагаан биш, гэхдээ шарласан туяагүй байна. Дунд үрийн 5-6 мм хэмжээтэй.
	Гурвалжин будаа	Гурвалжин будаа нь MNS 6611-2015 стандартад нийцсэн гадаад хэлбэр дүрс цэцгийн хайрснаас салгаж эвэрлэсэн гурвалжин будааны гурван талт самранцар үртэй байна энэ нь шаардлагад нийцсэн. Өнгө шаравтар болон бор туяатай цайвар өнгөтэй үнэр амт гурвалжин будааны өвөрмөц үнэр, амт эвгүй, хөгц зэрэг гашуун амт үнэргүй байна.
	Шар будаа	Шар будаа нь: MNS ISO 4833-95 стандартад нийцсэн өнгөлсөн цасгаан будаа САЗ 5-5-13 стандартад нийцсэн чийг 15%-иас ихгүй 10.85% цайвар шаргал өнгөтэй, хэвийн үнэртэй , гадны амт үнэргүй
	Хөц будаа	Хөц будаа нь: MNS 45:1997 стандартад нийцсэн будааны бүтэц, хэлбэр дүрсэнд өөрчлөлт гараагүй, цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирдоогүй, ариун цэврийн шаардлага хангасан хөц будаа байна.
	Хүүхдийн будаа	Хүүхдийн будаа нь: MNS CAC 178:2014 стандартад нийцсэн, цэвэр хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирдоогүй, ариун цэврийн шаардлага хангасан хүүхдийн будаа байна.
	Овьёос	Геркүлес нь: MNS 4293-95 гадаад хэлбэр дүрс цэцгийн хайрснаас салгаж цэвэрлэсэн шаардлагад нийцсэн. Өнгө шаравтар болон бор туяатай цайвар туяатай үнэр амт

		гурвалжин будааны өвөрмөц үнэр, амттай эвгүй, хөгц зэрэг гашуун амт үнэргүй байна. Бүтэн цөм 99.8%-иас ихгүй Бяцалсан цөм 0.2%-тай. Чийглэг 5.01%-тай хэмхтэс 0.2% хөнөөлт шавьж хачиг тэдгээгийн өндөг авгалдайгүй байна
	Вандуй	Вандуй нь: MNS ISO 5272-2003 стандартад нийцсэн гадны амт үнэргүй, органик ба органик бус хольц илрээгүй хөнөөлт шавьж, хачиг тэдгээрин өндөг, авгалдай, хүүхэлдэй илрээгүй
	Жимсний чанамал	Жимсний чанамал: MNS 4765:99 өөр өөрийн төрлийн үнэр амттай гадаргуу биет гэмтэлгүй, хортон шавьжны бохирдолгүй, чихрийн талтсгүй, чихэрлэг хуурай бодис 72.5%-тай байх. Жимс жимсгэнийг хурц үнэртэй өөр төрлийн бараатай хамт тээвэрлэхийг хориглоно. Түргэн гэмтдэг барааг тусгай зориулалтын машинаар чанарыг алдагдуулахгүйгээр тээвэрлэнэ.Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан орчин нөхцөлд хадгалах ба тээвэр зөөвөрлөх журмыг нарийн баримтлана.
	Төмс	<ol style="list-style-type: none"> 1. Нийлүүлэх төмс нь орон нутагт тариалагдсан, MNS 258:2006 стандартын шаардлага хангасан байна 2. Итгэмжлэгдсэн лабораторит улирлаар шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан 3. Шинэ буюу шинэлэг байдлаа хадгалсан байх 4. Хортон, хөнөөлт шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй бүтэн, хуурай, сортынхоо хэблэр, дүрсийг хадгалсан байх 5. Хальсан нь шалбарсан төмс 10%-иас ихгүй, ногоорсон төмсгүй, пестицидийн үлдэгдэлгүй байх 6. Гадны ямар нэг үнэртэй, химийг бодисоор бохирлогдсон байж болохгүй 7. Төмсний голч хэмжээ 35-55мм, 55мм-с дээш байна 8. Төмсний норох, хөлдхөөс хамгаалж бүтээлэгтэй тээврийн хэрэглэсээр тээвэрлэнэ 9. Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар 1 удаагийн нийлүүлэлтийг хийнэ
	Брокли, бууцай,	Бууцай -MNS 0274:1982, Цэцэгт байцаа -MNS 0257:1966 Ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд оруулсан байх. Хортон, хөнөөлт шавьжаар гэмтээгүй, эрүүл хагаралтгүй,

Багц 5 Хүнсний ногоо	Чанцай	хөгшрөөгүй, наалдсан шороогүй, хуурай соортынхоо хэлбэр дүрсийг хадгалсан байна
	Байцаа	<ol style="list-style-type: none"> 1. Нийлүүлэх байцаа нь орон нутагт тариалагдсан MNS 0255:2007 стандартын шаардлага хангасан монгол байцаа байх 2. Итгэмжлэгдсэн лабораторит улирлаар шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан байх 3. Байцаа нь нягтрал сайтай, бүтэн, цэвэр, өвчлөөгүй, хортон, хөнөөлт шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй, механик элдэв хольцгүй гадны үнэр амтгүй, сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан байна. 4. Хадгалсан байцааг нийлүүлэхдээ гадна талын муудсан навчийг авч цэвэрлэсэн байх ба хөлдөлт, хайрагдалтгүй, жин нь 1.5кг-с доошгүй байна 5. Байцааг MNS 3529:1983 стандартын шаардлага хангасан шуудайд хадгалж тээвэрлэх 6. Байцааг норох, хөлдөх бохирдогдохоос хамгаалж тээвэрлэнэ 7. Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар 1 удаагийн нийлүүлэлтийг хийнэ
	Сонгино	<ol style="list-style-type: none"> 1. Нийлүүлэх сонгино нь орон нутагт тариалагдсан MNS 0260:1982 стандартын шаардлага хангасан монгол сонгино байх 2. Итгэмжлэгдсэн лабораторит улирлаар шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан байх 3. Сонгино нь мяханик элдэв хольцгүй, хортон, хөнөөлт шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй, эрүүл цэвэр хуурай сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан байна. 4. Булцуу нь нягт ургаж соёолоогүй, ялзраагүй, хатаж чийгээ алдаагүй, ааг амт сайтай байна 5. Сонгиныг стандартын шаардлага хангасан шуудай төрөн уутанд зэрэг соортоор нь ялгаж салгасан байна. 6. Сонгиныг норох хөлдөхөөс хаамгаалсан тээврийн хэрэгсэлээр тээвэрлэнэ. 7. Бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар 1 удаагийн нийлүүлэлтийг хийнэ
	Лууван	<ol style="list-style-type: none"> 1. Нийлүүлэх лууван нь орон нутагт тариалагдсан MNS 0271:1982 стандартын шаардлага хангасан 1 сорт байна 2. Итгэмжлэгдсэн лабораторит улирлаар шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан байх 3. Лууван нь нягт шүүслэг хөндийрөөгүй модорч хөгшрөөгүй, өлсөж үрчийгээгүй,

		<p>соёолоогүй гэмтээгүй, ялзраагүй мяханик элдэр хольцгүй гадны үнэр амтгүй байна</p> <ol style="list-style-type: none"> 4. Савлалт нь хуурай, цэвэр даавуун шуудайд савласан байна 5. Лууванг норох хөлдөх гэмтгээс хаамгаалсан тээврийн хэрэгсэлээр тээвэрлэнэ. 6. Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар 1 удаагийн нийлүүлэлтийг хийнэ
	Хүрэн манжин	<ol style="list-style-type: none"> 1. Нийлүүлэх манжин нь орон нутагт тариалагдсан MNS 0268:1973 стандартын шаардлага хангасан монгол 1-р зэгийн байх 2. Итгэмжлэгдсэн лабораторит улирлаар шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан байх 3. Ил болон хамгаалагдсан хөрсөнд ургуулсан манжин нийлүүлнэ. 4. Хортон хөнөөлт шавьжаар гэмтээгүй үндэс үр нь шинэ бүтэн эрүүл хагаралтгүй хөгшрөөгүй наалдсан шороогүй хуурай сортынхоо хэлбэр дүрсийг хадгалсан байна 5. Савлалт нь хуурай цэвэр шуудайнд савласан байх 6. Ногоог норох хөлдөхөөс хаамгаалсан тээврийн хэрэгсэлээр тээвэрлэнэ. 7. Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар 1 удаагийн нийлүүлэлтийг хийнэ
	Улаан лооль Чинжүү	<p>Улаан лооль - MNS ISO 5524:2003, Амтат чинжүү - MNS ISO 6659:2003</p> <ol style="list-style-type: none"> 1. Ариун цэвэр эрүүл ахуйн шинжилгээнд оруулсан байх 2. Хортон хөнөөлт шавьжаар гэмтээгүй үндэс үр нь шинэ бүтэн эрүүл хагаралтгүй хөгшрөөгүй наалдсан шороогүй хуурай 3. Савлалт нь хуурай цэвэр шуудайнд савласан байх 4. Ногоог норох хөлдөхөөс хаамгаалсан тээврийн хэрэгсэлээр тээвэрлэнэ
	Өргөст хэмх	<ol style="list-style-type: none"> 1. Өргөст хэмх -MNS ISO 7560:2003 2.Гарал үүслийн гэрчилгээтэй байна. 3.Өнгө үзэмж сайтай байх 4.Эрүүл ахуйн шаардлага хангасан байх

		<p>5.Хүнсний бүтээгдэхүүний стандартад нийцсэн байх</p> <p>6.Тээвэрлэлт, хадгалалт, хамгаалалтын шаардлага хангасан байна.</p> <p>7.Зориулалтын агуулах болон, бэлтгэн нийлүүлэгчээс шууд хангадаг байх</p> <p>8.Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх</p>
<p>Багц 6</p> <p>Жимс</p> <p>жимсгэнэ</p>	<p>Аньс, нэрс, чацаргана</p>	<p>Чацаргана жимс - MNS 0916:2011 Сайн чанарын эрүүл ахуйн ариун цэврийн стандарт шаардлагад нийцсэн технологийн шаардлага хангасан гадаад байдал амт ба үнэр боловсролт зэргийг амтлаж үзэх. Итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан байх. Аньстай дүйцэхүйц витаминлаг чанартай</p>
	<p>Зөгийн бал</p>	<p>MNS 4933:2000 Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн, технологийн шаардлага хангасан цэвэр байгаль экологийн, элсэн чихрээр өтгөрүүлээгүй, монгол үйлдвэрийн байх</p>